

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2011 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН БАЙДЛААР)

I. ТӨСӨВ:


Төсвийн орлого

Аймгийн төсөвт эхний 10 сард 4377.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1321.9 сая төгрөг буюу 43.3 хувиар өсчээ.

Төсвийн зарлага

Аймгийн нэгдсэн төсвийн зарлага эхний 10 сард 30802.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 5883.2 сая төгрөг буюу 23.6 хувиар өссөн байна. Төсвийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 5883.2 сая төгрөг буюу 23.6 хувиар өсөхөд цалин хөлс 4133.0 сая төгрөг буюу 29.4 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 347.7 сая төгрөг буюу 23.9 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 2527.7 сая төгрөг буюу 35.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төсвийн зарлагын 59.1 хувийг цалин хөлс, 5.8 хувийг НДШ, 31.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.4 хувийг татаас ба шилжүүлгийн зардал тус тус бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс цалин хөлсний эзлэх хувь 2.7 пунктээр, бараа үйлчилгээний бусад зардлын эзлэх хувь 2.7 пунктээр өсч, татаас ба шилжүүлгийнх 1.3 пунктээр буурсан байна.



Өглөг,авлага

Төсөвт газруудын өглөг 697.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 123.1 сая төгрөг буюу 21.4 хувиар өссөн байна. Өглөгийн 17.2 хувийг түлш халаалтын зардал, 20.3 хувийг тээврийн зардал, 5.1 хувийг цалин, 4.5 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 25.3 хувийг эмийн зардал, 7.5 хувийг хоолны зардал, 3.6 хувийг гэрэл цахилгааны зардал, 16.5 хувийг бусад зардал тус тус эзэлж байна. Өглөг өмнөх оны мөн үеийнхээс 21.4 хувиар өсөхөд эмийн өглөг 50.8 хувиар, хоолных 78.9 хувиар, тээврийнх 59.2 хувиар, түлш халаалтынх 13.7 хувиар, гэрэл цахилгааных 2.1 дахин өссөн нь нөлөөлжээ. Өмнөх оны мөн үеийнхээс эмийн эзлэх хувь 5.0 пунктээр, гэрэл цахилгааных 1.5 пунктээр, тээврийнх 4.8 пунктээр, хоолных 2.4 пунктээр өсч, түлш халаалтынх 1.1 пунктээр, цалингийнх 5.0 пунктээр тус тус буурсан байна.

II. АРИЛЖААНЫ БАНК.

Арилжааны банкуудын аж ахуй нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 10 сард 60457.3 сая төгрөг болж өмнөх оны мөн

үеийнхээс 27617.7 сая төгрөг буюу 84.1 хувиар өссөн байна. Зээлийн өрийн үлдэгдэл 84.1 хувиар өсөхөд хугацаа хэтэрсэн зээл 468.8 сая төгрөг буюу 3.0 дахин их өссөн нь нөлөөлсөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.8 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 пунктээр өссөн байна. Эхний 10 сард олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 60.9 хувь нь ХААН банк, 12.3 хувь нь Хадгаламж банк, 25.2 хувь нь Хас банк, 1.5 хувь нь Төрийн банкинд ногдож байна. Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 30583.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 10394.2 сая төгрөг буюу 51.5 хувиар өссөн байна. Эхний 10 сард 43242 хүнд 52898.4 сая төгрөгийн зээл олгож, байгууллага, иргэдээс 42487.2 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 16687.2 сая төгрөг зарлага 15678.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 3325.4 сая төгрөг буюу 24.9 хувиар, зарлага 2440.4 сая төгрөг буюу 18.4 хувиар нэмэгдлээ. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1377.4 сая төгрөг буюу 27.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага нэмэгдэхэд тэтгэвэр 2622.2 сая төгрөг буюу 23.7 хувиар, тэтгэмж 36.5 сая төгрөг буюу 8.2 хувиар, өссөн нь нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 13689.4 сая төгрөг болсны 80.1 хувийг өндөр настны, 13.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өндөр настны тэтгэвэр 2.0 пунктээр өсч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 1.3 пунктээр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.7 пунктээр буурсан байна.

Нийгмийн халамж:


Эхний 10 сард нийгмийн халамжийн сангаас эхний 10 сард 141425 хүнд 29765.2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 5839 хүнээр буюу 4.3 хувиар, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 18600.2 сая төгрөг буюу 2.6 дахин өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 2.9 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 1.7 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 0.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 0.8 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 6.2 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд, 81.1 хувь нь хүний хөгжил сангийн хишиг хувь авагчид байна. Нийгмийн халамжийн сангаас 29765.2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосоны 1240.1 сая төгрөг буюу 4.2 хувийг халамжийн тэтгэвэрт, 660.9 сая төгрөг буюу 2.2 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 1293.1 сая төгрөг буюу 4.3 хувийг алдарт эхийн одонтой эхчүүдэд, 321.1 сая төгрөг буюу 1.1 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 257.9 сая төгрөг буюу 0.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 85.5 хувийг хүний хөгжил сангийн хишиг хувь авагчдад зарцуулсан байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ:

Аймгийн хэмжээгээр 2011 оны эхэнд төллөх насны нийт 933.3 мянган эх мал тоологдсон. 2011 оны эхний 10 сарын байдлаар 818.8 мянган мал буюу


оны эхэнд тоологдсон нийт эх малын 87.7 хувь нь төллөсөн байна. Ингэний 56.9 хувь, гүүний 76.7 хувь, үнээний 78.1 хувь, эм хонины 88.2 хувь, эм ямааны 89.2 хувь нь төллөжээ.

Мал төллөлтийн хувь, 2011 оны эхний 10 сарын байдлаар




Гарсан төлийн 96.8 хувь буюу 794.2 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийн төл бойжилтын хувиас 43.8 функтээр их байна. Хурга 97.1 хувь, ишиг 97.3 хувь байгаа ба өмнөх оны мөн үеийнхээс төл бойжилтын хувь малын 5 төрөл тус бүр дээр өндөр байна.

Төл бойжилтын хувь, 2011 оны эхний 10 сарын байдлаар




Аймгийн хэмжээгээр 2011 оны эхний 10 сарын байдлаар 11 тэмээ, 786 адуу, 847 үхэр, 9.5 мянган хонь, 9.7 мянган ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 1.0 хувьтай тэнцэх 20.8 мянган том мал зүй бусаар хорогдоод байна.

Зүй бусаар хорогдсон том мал, 2011 оны эхний 10 сарын байдлаар




Нийт хорогдсон малын 0.05 хувийг тэмээ, 3.8 хувийг адуу, 4.1 хувийг үхэр, 45.4 хувийг хонь, 46.6 хувийг ямаа эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2011 оны эхний 10 сарын байдлаар Баян-Өндөр суманд 453 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Бүрд суманд 5.2 мянган толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.8 хувь, Баруунбаян-улаан суманд 441 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.4 хувь, Баянгол суманд 129 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.1 хувь, Гучин-Ус суманд 923 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.1 хувь, Есөнзүйл суманд 1010 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.1 хувь, Өлзийт суманд 1064 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.2 хувь, Зүүнбаян-Улаан суманд 381 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.6 хувь, Богд суманд 429 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Нарийн тээл суманд 2255 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.5 хувь, Сант суманд 13 толгой мал, Тарагт суманд 769 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.4 хувь, Төгрөг суманд 16 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.04 хувь, Уянга суманд 1844 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.5 хувь, Хайрхандулаан суманд 914 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.7 хувь, Хужирт суманд 890 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хархорин суманд 3.7 мянган толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.4 хувь, Арвайхээр суманд 403 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.8 хувь тус тус хорогдсон байна. Бат-Өлзий суманд том малын хорогдол гараагүй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар




Аймгийн хэмжээнд 2011 оны эхний 10 сард 472 толгой мал өвчнөөр хорогдсон нь Баруунбаян-Улаан суманд 1 тэмээ, Баянгол суманд 1 адуу, 16 хонь, 8 ямаа, Гучин-Ус суманд 2 хонь, Өлзийт суманд 1 адуу, 35 хонь, 41 ямаа, Зүүнбаян-Улаан суманд 3 адуу, 5 үхэр, 14 хонь, 12 ямаа, Богд суманд 5 хонь, 11 ямаа, Нарийнтээл суманд 5 хонь, 8 ямаа, Сант суманд 6 хонь, 7 ямаа, Тарагт суманд 35 хонь, Хайрхандулаан суманд 1 адуу, 2 хонь, Хужирт суманд 19 адуу, 14 үхэр, 105 хонь, 110 ямаа, Арвайхээр суманд 2 хонь, 3 ямаа тус тус өвчнөөр хорогдсон байна.

Хээлтэгчийн хорогдол эхний 9 сарын байдлаар 4342 толгой байгаа ба оны эхний хээлтэгчийн 20.8 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдсон хээлтэгч малын 0.1 хувийг ингэ, 4.7 хувийг гүү, 5.4 хувийг үнээ, 43.3 хувийг эм хонь, 46.4 хувийг эм ямаа эзэлж байна.


Аймгийн хэмжээнд 2100.0 га-д үр тариа, 312.0 га-д төмс, 147.26 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад үр тариа 383.3 га буюу 22.3 хувиар, төмс 30.8 га буюу 9.9 хувиар, хүнсний ногоо 5.06 га буюу 3.4 хувиар тус тус илүү тариалсан ба 2011 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд үр тариа хураалт 1620 га-аас 2057 тн, төмс 294.5 га-аас 3068.9 га, хүнсний ногоо 144.01 га-аас 1648.2 тн тус тус хураан аваад байна. 2011 онд 1 га талбайгаас 0.8 тн үр тариа, 10.4 тн төмс, 11.4 тн хүнсний ногоо хураан аваад байгааг урд оны га-гийн ургацтай харьцуулахад үр тариа урд оны түвшинд, төмс 0.9 тн-оор өндөр, хүнсний ногоо мөн 0.9 тн-оор өндөр байна.

Ургац хураалт, сумаар



Хадлан, тэжээл бэлтгэлтийн мэдээ 10 сарын байдлаар байгалийн хадлан 31.7 мянган тн, гар тэжээл 5.9 мянган тн бэлтгээд байгаа нь өмнөх оны мөн үеээс байгалын хадлан 385.4 тн буюу 1.5 хувиар, гар тэжээл бэлтгэлт 525 тн буюу 9.8 хувиар тус тус өндөр байна.

Хадлан, тэжээл бэлтгэл, сумаар




V. АЖ ҮЙЛДВЭР:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2011 оны эхний 10 сард (оны үнээр) 5166.7 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1353.7 сая төгрөг буюу 35.5 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, 1.1 хувь, цэвэр ус , талх, нарийн боов, хэрчсэн гурил, мод,модон эдлэл үйлдвэрлэл,хэвлэх, оёдол зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2 хувиас 16.0 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Архи, сүү, сүүн бүтээгдэхүүн, гутал зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9-42.2 хувиар буурсан байна.


Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нүүрс олборлолт (29.1 %),хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (42.0 %), оёдол (14.8 %),хэвлэх үйлдвэрлэл (22.4 %), Мод,модон эдлэлийн үйлдвэрлэл (24.8 %) , цахилгаан, дулаан, үйлдвэрлэл (13.2 %),ус ариутгал, усан хангамжийн үйлдвэрлэл (12.3 %), хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэлт 4.1 %) тус тус нэмэгдэж, гутал үйлдвэрлэл (42.2 %),-иар буурчээ. Үйлдвэрлэл эрхэлсэн цэг салбарын тоо өмнөх оны мөн үеийнхээс 10.4 хувиар нэмэгдсэн нь бүтээгдэхүүний өсөлтөд нөлөөлсөн байна.

Хүнсний зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн (оны үнээр 4887.2) сая төгрөгт хүрч, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 539.2 сая төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 3525.2 сая төгрөг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 822.8 сая төгрөгт хүрч, нийт борлуулалтад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 11.0 хувь болж 0.6 пунктээр буурч, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 72.1 хувь болж 3.8 пунктээр өсч, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 16.8 хувь болж 3.4 пунктээр буурлаа.

Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр




VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

Тээвэр

Авто замын тээврээр 2011 оны эхний 10 сард давхардсан тоогоор 146.2 мянган зорчигч зорчиж, 16.5 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 2.6 мян. хүн буюу 1.8 хувь, тээсэн ачаа 0.7 мян.тн буюу 4.4 хувиар нэмэгджээ

Зорчигч эргэлт, тээсэн ачаа



т хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 173.5 сая төгрөг буюу 17.9 хувиар өсчээ.

Холбоо

Холбооны тарифын орлого эхний 10 сард 217.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 20.9 сая төгрөг буюу 10.7 хувиар өсчээ. Хүн амаас орсон орлого нийт орлогын 20.0 хувийг эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 2.2 пунктээр буурсан байна.

Суурин утасны цэгийн тоо 1035 болж өмнөх оны мөн үеийнхээс 409 цэгээр буюу 28.3 хувиар буурсан байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:

Хэрэглээний үнийн индекс 10 сард өмнөх сартай харьцуулахад 1.0 хувиар буурч, өмнөх оны жилийн эцсийнхээс 4.4 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 6.9 хувиар өссөн байна.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 1.0 хувиар буурахад хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувиар буурсан байна. Үүнд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувиар, төрөл бүрийн өөх тосны дэд бүлгийн үнэ дүнгээрээ 10.4 хувиар, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дүнгээрээ 27.1 хувиар буурсан нь нөлөөлжээ. Мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5.5 хувиар буурахад хонины махны үнэ 5.7 хувиар, адууны махны үнэ 14.3 хувиар, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ буурахад төмсний үнэ 11.1 хувиар, луувангийнх 50.0 хувиар, манжингийнх 77.2 хувиар, байцааных 33.4 хувиар, сонгиных 11.1 хувиар буурсан нь тус тус нөлөөлжээ.

2011 оны 10 сарын үнийн индекс өмнөх оны жилийн эцсийнхээс 4.4 хувиар өссөний дотор хүнсний бараа согтууруулах бус ундааны үнэ бүлгийн дүнгээрээ 0.2 хувиар, гутал хувцас, бөс барааны үнэ бүлгийн дүнгээрээ 5.3 хувиар, орон сууц ус цахилгаан түлшний үнэ бүлгийн дүнгээрээ 15.0 хувиар, гэр ахуйн барааны үнэ бүлгийн дүнгээрээ 8.4 хувиар, тээврийн үнэ бүлгийн дүнгээрээ 13.9 хувиар, боловсролын үйлчилгээний үнэ бүлгийн дүнгээрээ 12.1 хувиар, согтууруулах ундаа тамхины үнэ бүлгийн дүнгээрээ 0.4 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Тээврийн бүлгийн үнэ 13.9 хувиар өсөхөд А-80 бензиний үнэ 18.9 хувиар, АИ-92 үнэ 16.3 хувиар, дизель түлшний үнэ 22.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Орон сууц цахилгаан түлшний үнэ бүлгийн дүнгээрээ 15.0 хувиар өсөхөд орон сууцны цахилгааны үнэ 5.3 хувиар, гэр хорооллын цахилгааны үнэ 5.5 хувиар, 1 тонн нүүрсний үнэ 42.8 хувиар, 1 шуудай түлээний модны үнэ 25.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.

VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд эхний 10 сард 25917.7 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2916.6 сая төгрөг буюу 12.7 хувиар өссөн байна. Аж ахуй нэгж иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 203 цэгээр буюу 19.3 хувиар өсчээ.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 12.7 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 11.2 хувиар, хүнсний дэлгүүрийнх 13.2 хувиар, авто сэлбэгийн дэлгүүрийнх 40.4 хувиар, барилгын материалынх 21.9 хувиар, ресторан барных 7.5 хувиар, цайны газрынх 1.9 хувиар, түцнийх 2.9 хувиар, авто засварын газрынх 74.7 хувиар, шатахуун борлуулалтынх 11.8 хувиар, эм борлуулалтынх 26.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бараа гүйлгээний орлогын 3.1 хувийг барааны дэлгүүр, 18.3 хувийг хүнсний дэлгүүр, 2.4 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 0.5 хувийг барилгын материалын дэлгүүр, 4.2 хувийг ресторан бар, 1.3 хувийг цайны газар, 0.2 хувийг түц, 3.0 хувийг контейнер, 2.0 хувийг авто засварын газар, 61.5 хувийг шатахуун борлуулалт, 3.5 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 10 сард 2085 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 240 эхээр буюу 10.3 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2086 болж, 244 хүүхэд буюу 10.5 хувиар буурсан байна.

Нэг хүртэлх насандаа 57 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 11 хүүхдээр буюу 16.2 хувиар буурч, 1-5 хүртэлх насандаа 14 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 4 хүүхдээр буюу 40.0 хувиар өссөн байна.

Халдварт өвчнөөр эхний 10 сард 1103 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 263 хүнээр буюу 31.3 хувиар өссөн нь вируст гипатитаар өвчлөгчдийн тоо 411 хүн буюу 3.6 дахин их, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 147 хүнээр буюу 3.7 дахин их, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 20 хүнээр буюу 19.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Мөн цусан суулгаар өвчлөгчид өмнөх оны мөн үеийнхээс 64 хүн буюу 80.0 хувь, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 55 хүн буюу 46.3 хувь, трихоминиазаар өвчлөгчдийн тоо 58 хүн буюу 60.5 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 5 хүн буюу 7.4 хувиар буурчээ.Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Богд суманд 37 хүнээр буюу 3.0 дахин, Гучин –Ус суманд 41 хүн буюу 3.9 дахин, Нарийнтээл суманд 37 хүн буюу 3.5 дахин, Уянга суманд 77 хүн буюу 2.0 дахин, Арвайхээр суманд 133 хүн буюу 1.3 дахин өсчээ.

X.АЖИЛГҮЙЧҮҮД:

Аймгийн ХХҮХ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2905 болж, өмнөх оны мөн үеийнхээс 211 хүнээр буюу 7.8 хувиар өсчээ.Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Батэлзий суманд 24 хүнээр, ББУлаан суманд 35 хүнээр, Баянгол суманд 40 хүнээр, Есөнзүйл суманд 14 хүнээр, Өлзийт суманд 15 хүнээр, Богд суманд 63 хүнээр, Нарийнтээл суманд 55 хүнээр, Төгрөг суманд 31 хүнээрУянга суманд 95 хүнээр, Хайрхандулаан суманд 64 хүнээр тус тус нэмэгдсэн нь ажилгүй нийт иргэдийн тооны өсөлтөд голлон нөлөөлжээ.Эхний 10 сард ажилгүй 168 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 250 иргэн ажилд зуучлагдан орж, 856 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. ХХҮХ-т эхний 10 сард шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 56 хүнээр буюу 50.0 хувиар өсчээ. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн дотроос бусад шалтгаанаар ажилгүй болсон иргэдийн тоо 6.5 дахин өмнөх оны мөн үеийнхээс өсч, орон тооны цомхотголоор ажилгүй болсон иргэдийн тоо 91.8 хувь, байгууллага татан буугдсан 75.0 хувь, өөр газраас шилжиж ирсэн 80.0 хувь, сургууль төгссөн 81.0 хувь, мэргэжлийн ажил олдоогүй шалтгаанаар ажилгүй болсон иргэдийн тоо 50.0 хувиар тус тус буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1627 буюу 56.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 5.5 пунктээр өссөн байна.


Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1582 буюу 54.4 хувь нь 16-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 14.3 хувь нь дээд, 5.3 хувь нь тусгай дунд, 5.4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 31.6 хувь нь бүрэн дунд, 35.9 хувь нь бүрэн бус дунд, 6.4 хувь нь бага, 1.1 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дээд боловсролтой иргэдийн тоо 0.8 пунктээр, тусгай дунд 0.4 пунктээр, бага 1.1 пунктээр, боловсролгүй 0.4 пунктээр өсч, бүрэн дунд

боловсролтой иргэдийн тоо 0.6 пунктээр, бүрэн бус дунд 1.9 пунктээр буурсан байна. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо эхний 10 сард 250 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.5 дахин өссөн байна.

Ажилд зуучлагдан орсон нийт иргэдийн 47.2 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 6.0 хувь нь нөхөрлөл компанид, 46.8 хувь нь бусад байгууллагад оржээ.

Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо



Оны эхний 10 сард 1457 ажлын байр шинээр бий болж, үүний 9.8 хувь нь барилгын салбарт, 40.7 хувь нь ХАА-н салбарт, 10.7 хувь нь боловсруулах үйлдвэрт, 9.2 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 7.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 3.9 хувь нь зочид буудал зоогийн газарт, 1.4 хувь нь боловсролын салбарт, 17.3 хувь нь бусад салбаруудад бий болсон байна.

ХИ.ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар 393 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 41 гэмт хэргээр буюу 11.6 хувиар өссөн байна. Үүнд өмнөх оны мөн үеийнхээс бусдын амийг хорлох гэмт хэрэг 25.0 хувиар, хулгайлах гэмт хэрэг 8.0 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 53.1 хувиар, иргэний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 11.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 64.9 хувь нь сумдад, 35.1 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 17 гэмт хэргээр буюу 3.1 дахин өсчээ. Хулгайлах гэмт хэргийн 55.4 хувийг иргэдийн орон байрны хулгай, 38.0 хувийг малын хулгай, 6.6 хувийг авто тээврийн хэрэгслийн хулгай тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс Нарийнтээл суманд 14.3 хувиар, Тарагт суманд 30.7 хувиар, Хархорин суманд 25.6 хувиар, Богд суманд 2.2 дахин, Бүрд суманд 2.0 дахин, ЗБУлаан суманд 27.3 хувиар, Арвайхээр суманд 17.9 хувиар, Баян-өндөр суманд 50.0 хувиар, Хужирт суманд 6.6 хувиар, Баянгол суманд 3.0 дахин нэмэгдэж, Гучин-Ус суманд 70.0 хувиар, ББУлаан суманд 28.6 хувиар, Төгрөг суманд 22.2 хувиар, Уянга суманд 20.0 хувиар, Бат-Өлзий суманд 6.9 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 39.9 хувийг хөнгөн хэрэг, 50.4 хувийг хүндэвтэр хэрэг, 5.6 хувийг хүнд хэрэг, 4.1 хувийг онц хүнд хэрэг тус тус эзэлж өмнөх оны

мөн үеийнхээс хөнгөн хэрэг 1.0 пунктээр, хүндэвтэр хэрэг 1.8 пунктээр, онц хүнд хэрэг 1.3 пунктээр өсч, хүнд хэрэг 3.7 пунктээр буурсан байна. Гэмт хэрэгт холбогдсон 369 сэжигтэн, яллагдагчийн 236 буюу 63.9 хувь нь 18-35 хүртэл насных, 92 буюу 24.9 хувь нь 35-аас дээш насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилчин ,малчины эзлэх хувь 32.2 хувь, төрийн албан хаагч 5.7 хувь, Оюутан, сурагч 11.1 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 6.0 хувь, ажилгүй иргэд 40.4 хувь байна.

Хамтран үйлдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 9.2 хувиар өсч, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг өмнөх оныхоос 22.2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 143 хүн гэмтэж, 90 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтэж бэртсэн хүний тоо 20 буюу 16.2 хувиар, нас барсан хүний тоо 20 буюу 28.5 хувиар тус тус өссөн байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
MAIN INDICATORS

11/6/2011

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2009	2010	2011	2011/2010%
Төсвийн орлого	/budget revenue/	сая.төг mln.tog	2960.9	3055.3	4377.2	143.3
Төсвийн зарлага	/Budget expenditure/	сая.төг mln.tog	21881.0	24919.3	30802.6	123.6
Зээлийн өрийн үлдэгдэл	/Remainder of loan debts/	сая.төг mln.tog	31866.4	32839.5	60457.3	184.1
Үүнээс: хугацаа хэтэрсэн	/whom: outstanding debts/	сая.төг mln.tog	560.3	229.9	698.7	3 дахин
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	16644.7	20188.9	30583.1	151.5
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	1244.3	541.1	818.8	151.3
Бойжсон төл	/rearing of young animals/	мян.тол /thous.heads/	1148.2	292.1	794.2	2.7 дахин
Том малын зүй бус хорогдол	/Losses of adult animals/	мян.тол /thous.heads/	102.2	1643.6	20.8	1.3
Ургац хураалт /total crops / :						
Үр тариа /Cereals/		тн /tn/	702	1088.5	2057.0	189.0
Төмс/Potatoes/		тн /tn/	2391.7	2655	3068.9	115.6
Хүнсний ногоо/Vegetable/		тн /tn/	1446.4	1458.5	1648.2	113.0
Аж үйлдвэрийн НБ	/Gross industrial output/	сая.төг mln.mog	2549.5	3813.1	5166.8	135.5
Борлуулсан бүтээгдэхүүн	/Sold production/	сая.төг mln.tog	2531.1	3600.9	4887.2	135.7
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	14.1	15.8	16.5	104.4
Зорчигч зргэлт	/Passenger turnover/	мян.хүн.км /thouspass.km/	30701.5	40296	42860.9	106.4
Холбооны орлого	/Revenue of communication/	сая.төг mln.tog	243.8	196.2	217.1	110.7
Телефон цэг	/Number of telephones/	тоо/number/	1671	1444	1035	71.7
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	2907	2627	2905	110.6
Халдварт өвчнөөр өвчлөгчид disease cases/	/number of infectious	хүн/people/	850	840	1103	131.3
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд /infant deaths at age of 1 years/		хүн/people/	57	68	57	83.8
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	307	352	393	111.6
Хэрэгт холбогдогсад /Offenders/		хүн/people/	333	346	369	106.6

1.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг
 BUDGET EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Зарлага <i>Expenditure</i>		
	2011		
	төл	гүйц	%
Баян-Өндөр	740,920.2	675,161.1	91.1
Бүрд	604,948.4	611,679.8	101.1
Бат-Өлзий	1,188,131.3	1,076,679.0	90.6
ББ-Улаан	681,874.2	623,898.3	91.5
Баянгол	735,125.1	718,307.0	97.7
Гучин-Ус	618,154.8	597,480.2	96.7
Есөнзүйл	755,290.2	711,322.5	94.2
Өлзийт	585,075.8	572,300.5	97.8
ЗБ-Улаан	636,500.9	633,675.0	99.6
Богд	1,087,251.6	997,248.2	91.7
Нарийнтээл	840,660.9	809,205.4	96.3
Сант	786,425.2	733,100.5	93.2
Тарагт	654,086.8	603,679.8	92.3
Төгрөг	698,076.8	685,876.3	98.3
Уянга	1,494,551.5	1,407,673.5	94.2
Хайрхандулаан	692,028.2	692,663.1	100.1
Хужирт	1,172,772.4	1,166,485.4	99.5
Хархорин	2,571,114.4	2,436,371.9	94.8
Арвайхээр	4,296,931.1	4,190,183.1	97.5
Сум дүн <i>Soum total</i>	20839919.8	19942990.6	95.7
Татварын хэлтэс			
Аимгийн шууд	11,445,093.4	10,859,601.4	94.9
Аймаг дүн <i>Aimag total</i>	32285013.2	30802592.0	95.4

1.ТӨСӨВ

BUDJET

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг
STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн орлого	гүйц	2011		Budget revenue
	2010	төл	гүйц	
Татварын орлого	2812968	2594083.7	4011147.5	Tax revenue
-Хүн амын орлого	1490725	1703853	2089099	-Individuals
- Өмчийн татвар	62710.3	42438.3	77225.1	-Property tax
- Бусад татвар	628418.3	485636.8	759835.3	-Other tax
Татварын бус орлого	195480.8	203253.3	268626.6	Non-tax revenue
Хөрөнгийн орлого	46845.2	18900.0	97466.8	Capital revenue
Дүн	3055294	2816237.0	4377240.9	Total

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг
STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн зарлага	гүйц	2011		Budget expenditure
	2010	төл	гүйц	
-Цалин хөлс	14073225	18716234	18206276	-Wages&salaries
-Нийгмийн даатгалын шимтгэл	1456080	1929959.3	1803798.8	-Social security contribution
-Эрүүл мэндийн даатгал	1427.6	7691.6	95475.8	-Health insurance
-Бараа үйлчилгээний бусад зардал	7095709	10352328	9623404.1	-Goods and services expenses
Татаас ба шилжүүлэг	1186787	1249800.6	1064137.3	-Subsidie & transfers
-Хөрөнгө оруулалт	1106113	29000	9500	-Investment
НИЙТ ЗАРДАЛ	24919342	32285013.2	30802592.0	TOTAL EXPENDITURE

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

ӨГЛӨГИЙН МЭДЭЭ

11/6/2011

	Нийт өглөг	Үүнээс:									
		Ажиллагсад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	Эрүүл мэндийн даатгалын хэмжээ	Гэрэл цахилгаан	Түлш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	Хоол	Эм	Бусад
Эхний үлдэгдэл	678157.2	46292.6	33696.1	0.0	26846.4	99239.3	113412.4	2340.9	64804.2	191734.9	99790.4
Тухайн сард төлөгдсөн өглөг	152563.6	22701.0	17060.6	0.0	5296.9	10659.7	24730.3	236.7	25598.7	27277.9	19001.8
Тухайн сард шинээр үүсэн өглөг	171537.3	12196.6	14529.1	813.3	3816.7	31079.7	53036.4	1110.6	13080.6	11812.0	30062.3
Эцсийн үлдэгдэл	697130.9	35788.2	31164.6	813.3	25366.2	119659.3	141718.5	3214.8	52286.1	176269.0	110850.9
өглөг үүсэн хугацаа	31-60 өдөр	30038.2	21398.4	413.3	3924.7	31859.8	93148.7	1369.9	36819.3	36695.0	71091.7
	61-120 өдөр	289280.0	5750.0	9766.2	400.0	21441.5	14256.7	45754.5	1844.9	13253.0	139574.0
	121 өдрөөс дээш	83305.7					73542.8	2815.3	2213.8		2520

БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/

11/6/2011

д/д	Үзүүлэлтүүд	Indicators	ХААН банк Khan bank	Хадгаламж банк Saving bank	ХАС банк Khas bank	Төрийн банк bank
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал		13410000.0	3939200.0	3602060.0	225000.0
2	Банкны кассын орлого		36466871.0	26828978.2	29151268.9	6239468.4
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас		14189450.0	5050.0	3958940.0	53000.0
4	Банкны кассын зарлага		35153875.0	26460440.3	29446273	5551238.6
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл		36840786.0	7426338.3	15268780	921366.1
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл		566847.0	12651.1	111118.2	8114.9
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж		19628352.0	5632561.5	3973765.1	1348414.5
8		Дүн	156256181.0	70305219.4	85512204.6	14346602.5

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ

мян.төг

Үзүүлэлтүүд						Өссөн дүнгээр	
1	Орлого	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого				Төлөвлөгөө	15609070.2
						Гүйцэтгэл	16687256.1
						Хувь	106.9
	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	10204500.0	
					Гүйцэтгэл	10204500.0	
					Хувь	100.0	
		НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	5404570.2	
					Гүйцэтгэл	6482756.1	
					Хувь	119.9	
	Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	252146.9	
					Гүйцэтгэл	427232.2	
					Хувь	169.4	
	Үүнээс	Үүнээс	ЭМД-ын сангийн орлого		Төлөвлөгөө	1413216.0	
					Гүйцэтгэл	1757949.7	
					Хувь	124.4	
Үүнээс	Үүнээс	ЭМД-ын хураамж	Төлөвлөгөө	421603.6			
			Гүйцэтгэл	251802.7			
			Хувь	59.7			
2	Зарлага	Тэтгэвэр			Хүний тоо	12187	
					Олгосон нь	13689452.7	
		Үүнээс	Өндөр настны		Хүний тоо	9316	
					Олгосон нь	10971082.1	
			ХБИргэдийн		Хүний тоо	1902	
					Олгосон нь	1801582.8	
		Тэжээгчээ алдсаны		Хүний тоо	969		
				Олгосон нь	916787.8		
		Тэтгэмж			Хүний тоо	1696	
					Олгосон нь	482227.8	
		Эмнэлгийн санхүүжилт			Олговол зохих нь	1452572.9	
					Олгосон нь	1452572.9	
		Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон			Хүний тоо	104	
					Олгосон нь	54065.7	
		3	НДШ-ийн авлага			Бүгд	
үүнээс	аж ахуйн нэгж					11606.6	
	төсвийн					24667.5	

07-Nov-11

НДХ-ийн мэдээг үндэслэв.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТИЙН МЭДЭЭ

Үзүүлэлт	Хамрагдсан хүн	Дүн
зарлага	141425	29765235
Халамжийн тэтгэвэр	2400	1240933.1
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2424	620722.7
